

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2018.08.20

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ЧДХААА ОНОТХҮ18/004 дугаар бүхий “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг зорилтод бүлгийн иргэдэд өдрийн үйлчилгээнд хамруулах аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага сонгон шалгаруулах” ажлыг гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 /тавин мянга/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Төрийн сан банкны 100200751009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг **2018 оны 08 сарын 27-ны 13 цаг 00 минутаас өмнө Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 5 дугаар давхар, 511 тоот** гэх хаягаар ирүүлнэ.

Уг үйлчилгээг гэрээ байгуулснаас хойш 2018 оны 12 дугаар сарын 31-ийг дуустал хийж гүйцэтгэх болно.

Тендерт оролцогч нь тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлалтай, Нийгмийн халамжийн асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллагаас үйлчилгээ явуулах магадлан итгэмжлэлийн батламж авсан хуулийн этгээд байх бөгөөд санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сүүлийн 1 жил **/2017-ийн жилийн эцсийн тайланг ирүүлнэ.**
2. Тендерт оролцогч нь сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны аль нэг жилд оролцох багцийн үйлчилгээг хамгийн багадаа нийлбэр дүн нь **5 000 000 /таван сая/** төгрөгөөр гүйцэтгэсэн байна.
3. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас олгодог **/магадлан итгэмжлэл/** тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбарыг гэрээ, хавсралтын хамт тус тус **нотариатаар баталгаажуулж** ирүүлнэ.

Тендерийг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 сарын 27-ны 13 цаг 30** минутад нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй.

Дотоодны давуу эрх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16,
Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй
дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр Худалдан авах
ажиллагааны алба 5 дугаар давхар, 511 тоот*

Утас : 70110769